

БАТЛАВ.  
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ГАНХУЯГ

ТЭЭВЭРЛЭЛТИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2021 оны .... дүгээр сарын .... өдөр

№....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол улсын холбогдох хуулийг үндэслэн нэг талаас: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв хаягт байрлах 5435528 регистрийн дугаартай “Эрдэнэс Тавантолгой” ХК (цаашид “ЭТТ” ХК гэх), түүнийг төлөөлж Тээвэр, зохицуулалтын хэлтсийн дарга Н.Элдэв-Очир нөгөө талаас: .....тоот байрлах ..... регистрийн дугаартай “.....” ХХК (цаашид “Тээвэрлэгч” гэх) түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал ..... овогтой ..... нар (цаашид хамтад нь “талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож “Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ” (цаашид “гэрээ” гэх)-г байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Нүүрс тээвэрлэлтийг Монгол Улсын Олон улсын гэрээ, хэлэлцээр болон бусад хууль тогтоомж, холбогдох эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон Өмнөговь аймгийн Цогтцэций сумын (“Тавантолгой – Цагаан хад”, “Цагаан хад – Гашуунсухайт – Ганцмод”, “Тавантолгой – Ханги – Мандал”, “Тавантолгой – Чойр – Замын-Үүд – Эрээн”) чиглэлийн улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, түүнд хяналт тавих, Уурхайн бүс болон Гаалийн хяналтын бүсэд тээвэрлэлтийг гүйцэтгэхэд “ЭТТ” ХК, Тээвэрлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино;
- 1.2. Нүүрс тээвэрлэлтийг “Тавантолгой-Гашуунсухайт-Ганцмод” (уртын урт) чиглэлээр тээвэрлэх тохиолдолд Тээвэрлэгч энэхүү гэрээний 1.1-д заасан “Тавантолгой – Цагаан хад, Цагаан хад – Гашуунсухайт – Ганцмод” чиглэлээр тээвэрлэлт хийхгүй болно;
- 1.3. Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх Тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн тоо нь “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ MNS 5346:2017” стандартын “С”, зэрэглэлээс доошгүй, Тээвэрлэгчийн үйл ажиллагаа нь ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр мэргэшсэн, санхүүгийн чадамжтай, дотоодын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээг 3-аас доошгүй жил эрхэлсэн байх шаардлагыг хангасан байна. (Тээвэрлэгч нь “авто машинаар ачаа тээвэр хийх” тусгай зөвшөөрөлтэй гэрчилгээг авч 3-аас доошгүй жил үйл ажиллагааг эрхэлсэн байх);
- 1.4. Гэрээний хугацаа: Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна;
- 1.5. “Тээвэрлэгч компанийн бүрдүүлэх баримт бичиг” /Хавсралт 1/ нь гэрээний салшгүй хэсэг байна;

ХОЁР. “ЭТТ” ХК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Хятад Ард улсын Засгийн Газар хоорондын автотээврийн хэлэлцээр, хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай яамд хоорондын протокол болон

холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг бүрэн хангаж ажиллахыг тээвэрлэгчээс шаардах, хяналт тавих эрхтэй;

- 2.2. “ЭТТ” ХК нь “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Гашуун сухайт автозам” ХХК-тай хамтран өдөрт ачих тээврийн хэрэгслийн тоог төлөвлөн, батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлтийн үйлчилгээ, нүүрс ачилтыг зохион байгуулах, хяналт тавих үүрэгтэй;
- 2.3. Холбогдох байгууллагуудтай хамтран эсхүл дангаараа төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажил зохион байгуулах, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах арга зүйн зөвлөгөө өгнө;
- 2.4. Тээвэрлэгч компанийн үйл ажиллагаа болон энэхүү гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор “ЭТТ” ХК-ийн Салбарын захирал, уурхайн тээвэр хариуцсан ажилтан, талбайн мастер, талбайн зохицуулагч, ахлах ажилтнууд дараах арга хэмжээг авах эрхтэй. Үүнд:
  - 2.4.1. Тээвэрлэгч компанийн тээврийн хэрэгслийн жолооч болон хөтөч ажил үүргээ гүйцэтгэж байхдаа хүнд гэмтэл авсан, нас барсан тохиолдолд тухайн тээврийн хэрэгсэл, Тээвэрлэгчийн үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн тодорхой хугацаагаар зогсоох;
  - 2.4.2. Нүүрс тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх явцад маршрутын бус замаар дараалал дайрч нэвтэрсэн жолоочийн уурхайн амнаас ачилт хийх эрхийг 7-10 хоногоор хязгаарлах;
  - 2.4.3. Гаалийн хяналтын бүсрүү нэвтрэхдээ жолооны үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, арлын дугаарыг өөрчлөх, хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэрэг зөрчил гаргасан тохиолдолд замын цагдаагийн журмын дагуу шалгуулж, ачилт хийх эрхийг 7-10 хоногоор хязгаарлах;
  - 2.4.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх явцад “ЭТТ” ХК-ийн бүртгэлийн санд Тээвэрлэгчид бүртгэлгүй автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэлт гүйцэтгүүлсэн тохиолдолд ажилтныг уурхайн бүс рүү нэвтрүүлэхгүй байх, ачилтанд тодорхой хугацаанд оруулахгүй байх;
  - 2.4.5. Тээвэрлэгч болон тэдгээрийн гэрээт компаниудын жолооч нь “ЭТТ” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбай, ачилтын бүс зэрэгт нэвтрэхдээ бүх төрлийн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх мөн “ЭТТ” ХК-ийн ажилтан, хамгаалагчийн шаардлагыг биелүүлэхээс татгалзах, хэл амаар доромжлох, зүй бусаар харьцах, танхайрсан тохиолдолд тухайн жолоочийн ачилт хийх эрхийг хасах;
- 2.5. Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ байгуулсан компанийн мэдээллийг өөрийн [www.ett.mn](http://www.ett.mn) цахим хуудасны “Нээлттэй тээврийн цахим цонх”-оор дамжуулан олон нийтэд мэдээлнэ;
- 2.6. “ЭТТ” ХК-тай гэрээ байгуулсан тээвэрлэгчийг GPS, RFID-ийн системд холбуулах ажлыг зохион байгуулна;
- 2.7. Маршрутад заасан зам, холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд тухайн тээврийн хэрэгсэл болон жолоочийг уурхайн бүсэд нэвтрэх эрхийг 7 хоногоор хасах, давтан зөрчил гаргасан жолооч болон тээврийн хэрэгслийг нүүрс ачилтын бүс руу нэвтрүүлэх эрхийг 30 хоногоор хасах, эсвэл тухайн компани, жолооч, тээврийн хэрэгслийг онооны системд оруулж, хүний оролцоогүйгээр програмаар үнэлэн системээс хасах хүртэл арга хэмжээ авах эрхтэй;

- 2.8. Тээвэрлэгч нь “ЭТТ” ХК-ийн бүртгэлийн бүрдүүлэлт хяналт, шалгалт болон гэрээ байгуулах явцад удаа дараа хуурамч бичиг баримт ирүүлсэн нь нотлогдсон тохиолдолд энэхүү гэрээг “ЭТТ” ХК нь өөрийн санаачилгаар цуцлах эрхтэй;
- 2.9. Худалдан авагч талтай байгуулсан “Нүүрс тээврийн гэрээ” мөн нүүрс буулгах зориулалтын гаалийн хяналтын бүсээс өөр газар худалдан авагч тал болон “ЭТТ” ХК-ийн зөвшөөрөлгүйгээр тухайн нүүрсийг буулгахыг чанд хориглох ба зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээг “ЭТТ” ХК-ийн санаачилгаар цуцлах эрхтэй;
- 2.10. Харьяа орон нутаг болон, зам хариуцагч аж ахуйн нэгжээс батлагдсан маршрутын бус замаар удаа дараа тээвэр гүйцэтгэж салаа зам үүсгэж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн тохиолдолд учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, энэхүү гэрээг “ЭТТ” ХК-ийн санаачилгаар цуцлах эрхтэй;

### ГУРАВ. ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард улсын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээр, хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай яамд хоорондын протокол болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй;
- 3.2. Тээвэрлэгч нь энэхүү гэрээний Хавсралт 1-д заагдсан баримт бичгийн бүрдэл болон үйл ажиллагааны зааварчлагыг бүрэн мөрдөж ажиллана;
- 3.3. Гэрээний хугацаанд Тээвэрлэгч нь жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулсан, тээврийн хэрэгсэл нь даатгагдсан хүчин төгөлдөр даатгалтай байна;
- 3.4. “ЭТТ” ХК-ийн Тээвэр хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны мэргэжилтнүүд энэхүү гэрээнд заасан хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд Тээвэрлэгч болон түүний ажилтнууд тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй;
- 3.5. Тээвэрлэгч нь худалдан авагчтай “Нүүрс тээвэрлэх гэрээ”-г байгуулахдаа улсын хил хүртэл Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тээвэрлэлттэй холбоотой хууль, дүрэм, журам, төрийн захиргааны байгууллагаас гаргасан эрх зүйн акт болон жишиг тарифыг баримтлана;
- 3.6. Тээвэрлэгч нь “ЭТТ” ХК болон худалдан авагч нарын хооронд байгуулсан нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу Нүүрс тээврийн гэрээ байгуулахдаа тухайн гэрээнд сар бүрийн тээвэрлэлтийн хуваарийг тусгаж мөрдөж ажиллана;
- 3.7. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн баримт бичиг /замын хуудас, улс хоорондын зөвшөөрлийн бичгүүд/-тэй тээвэрлэлт гүйцэтгэх үүрэгтэй;
- 3.8. Тээвэрлэлтийн явцад зам тээврийн осол зөрчил гаргасан тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт дахин хамрагдсан тохиолдолд тээвэрлэлт гүйцэтгэнэ;
- 3.9. Батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлтийг зохион байгуулна;
- 3.10. Тээвэрлэгч нь “ЭТТ” ХК-ийн GPS, RFID-ийн системд заавал холбогдсон байх шаардлагатай бөгөөд уг системд нийцэн холбогдох тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөөр өөрсдийн тээврийн хэрэгсэл дээр суурилуулсан байна;
- 3.11. Нүүрс тээврийн хэрэгслүүдэд “ЭТТ” гэх тэмдэглэл бүхий таних тэмдэг байрлуулна;

- 3.12. Тээвэрлэлт хийх чиглэлийг салхины шилэн дээр байрлуулах, чиргүүлийн дээд хэсэгт тонн жингийн хэмжээг бичих;
- 3.13. Тээвэрлэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль орчинтой холбоотой дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 3.13.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчинтой холбоотой хууль, дүрэм, журам түүнд нийцүүлэн гаргасан “ЭТТ” ХК-ийн тушаал, шийдвэр, дүрэм журмыг өөрийн ажилтнуудад (үүнд туслан гүйцэтгэгчид орно) танилцуулах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, мөрдүүлэх, сургалт зохион байгуулах;
- 3.13.2. “ЭТТ” ХК-ийн тусгай зөвшөөрөл бүхий талбайд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчны зааварчилгааны дагуу ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд “ЭТТ” ХК-д учирсан бүхий л хохирлыг Тээвэрлэгч бүрэн хариуцах;
- 3.13.3. “ЭТТ” ХК-ийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль орчны асуудлаар үүсч болох бүх төрлийн хариуцлага, нэхэмжлэл, шаардлага, алдагдал, үүрэг, зардлаас ангид байлгах үүрэгтэй ба хэрэв дор дурдсан нөхцөлүүд бодитоор үүссэн тохиолдолд Тээвэрлэгч нь хохирлыг “ЭТТ” ХК-д нөхөн төлөх, түүнийг хохиролгүй болгох үүрэгтэй. Үүнд:
- a) энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад “ЭТТ” ХК эсхүл Тээвэрлэгчийн ажилтны эрүүл мэндэд хохирол учрах, ажилтан нас барах, гэмтэж бэртэх зэрэг бодит хохирол учирсан;
- b) энэхүү гэрээтэй холбоотойгоор Тээвэрлэгч түүний ажилтан, төлөөлөгч, гэрээт эсхүл туслан гүйцэтгэгчийн аливаа хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөнөөс үүдэж “ЭТТ” ХК-д эд хөрөнгийн хохирол учирсан;
- c) Тээвэрлэгч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.3 дахь хэсэгт заасны дагуу өөрийн гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудтай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж оруулсан байх үүргээ биелүүлээгүйгээс хохирол учирсан;
- 3.14. Тээвэрлэгч түүний гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын ажилтан, ажиллагсад үйл ажиллагаандаа Монгол Улсын байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг баримталж ажиллах үүрэгтэй бөгөөд хүрээлэн буй орчин, ус, хөрс бохирдуулах, “ЭТТ” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд ил задгай хог хаях, түлш асгах зэргээр байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхийг хориглоно. Ажиллаж буй орчин, ус, хөрс бохирдуулсан нөхцөлд өөрсдийн зардлаар нөхөн сэргээлтийн арга хэмжээг авах;
- 3.14.1. Тээвэрлэгч нь өөрийн болон гэрээт, туслан гүйцэтгэгч компаниудын тээврийн хэрэгсэл, жолооч нарыг тээврийн хэрэгслийн, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд мөн өөрийн ажилтнуудыг амь нас, эрүүл мэндийг зохих даатгалд даатгуулсан байх;
- 3.14.2. Жолоочийг ажилд гарахын өмнө эмчийн үзлэгт хамруулсан байх;
- 3.14.3. Уурхайн бүсэд нэг бүрийн хамгаалах хэрэгсэл тогтмол хэрэглэх;
- 3.15. “ЭТТ” ХК нь энэ зүйлд заасан хохирлыг нөхөн төлөх нөхцөл байдал үүссэн талаар Тээвэрлэгчид даруй мэдэгдэх бөгөөд энэ зүйлийн дагуу “ЭТТ” ХК-ийн эрхийг хамгаалах талаар шаардсан, биелүүлэх үндэслэл бүхий бүх зүйлийг Тээвэрлэгч хийж гүйцэтгэнэ;

- 3.16. Тээвэрлэгч болон Худалдан авагчийн хооронд байгуулсан “Нүүрс тээвэрлэх гэрээ”-ний дагуу нүүрс ачилтын үйл ажиллагаа түр хугацаанд зогсох болсон тохиолдолд Тээвэрлэгч нь энэ талаар жолоочид урьдчилан мэдэгдэх бөгөөд Зам тээврийн сайдын 2015 оны 339 дүгээр тушаалаар батлагдсан “Жолоочийн хөдөлмөр, амралтын горим, түүнийг мөрдөх тухай зөвлөмж”-ийг баримтална;

#### ДӨРӨВ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 4.1. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ бичгээр гаргаж, харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Бичгээр үйлдсэн нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно;

#### ТАВ. ГЭРЭЭ ДҮГНЭХ, ХАРИУЦЛАГА ТООЦОХ

- 5.1. “ЭТТ” ХК гэрээний үүргийн биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэх бөгөөд гэрээ дүгнэсэн актыг үндэслэн цаашид гэрээг сунгах, түдгэлзэх, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ;
- 5.2. ЭТТ” ХК нь Тээвэрлэгчийг энэхүү гэрээг зөрчсөн гэж дүгнэсэн тохиолдолд холбогдох дүгнэлтийг “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-т мэдэгдэх бөгөөд “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ нь Тээврийн нэгдсэн системээс тухайн Тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн улс хоорондын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх, зорчих зөвшөөрлийн бичгийг хураах, олголтыг түр зогсоолгох хүртэл арга хэмжээ авна;

#### ЗУРГАА. УЛС ХООРОНД БАЙНГЫН АЧАА ТЭЭВЭРЛЭХ “С” ТӨРЛИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

- 6.1. Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх “С” зөвшөөрөлийн хүсэлтийг баталгаажуулахдаа “ЭТТ” ХК борлуулалтыг дэмжих тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан үзэж баталгаажуулна. Үндсэн шалгуур үзүүлэлтүүд:
- 6.1.1. Худалдан авагч талтай байгуулсан “Нүүрс худалдах, худалдан авах гэрээ”-ний нөхцөл олон улсын худалдааны инкотермс FCA/DAP нөхцөлийг харгалзах;
- 6.1.2. Худалдан авагч талын Цагаанхадны НАБТ-н үлдэгдэл, тээвэрлэлтийн төлөвлөгөөг харгалзан тээврийн компанитай “Нүүрс тээврийн гэрээ”-г байгуулж “ЭТТ” ХК-д хүргүүлсэн хүсэлтийг харгалзах;
- 6.1.3. Экспортын тээврийн эрчимжүүлэх, тасралтгүй зохион байгуулах зорилгын хүрээнд битүүмжилсэн багийн системийг харгалзах;
- 6.1.4. Цахим үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”, Улс хоорондын хил нэвтрэх “С” зөвшөөрлийн хүсэлтийг батлахдаа санамсаргүй байдлаар сонгогдох системийг харгалзана;
- 6.2. “ЭТТ” ХК нь Тээвэрлэгчийн шаардлага хангасан тээврийн хэрэгслийн 25% хүртэл энэ гэрээний 6.1 дэх хэсэгт заасан нөхцөлөөр улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх “С” зөвшөөрлийн хүсэлтийг баталгаажуулна;
- 6.3. Дээрх 6.1.1, 6.1.2, 6.1.3 дэх хэсгийн шалгуур үзүүлэлтийг хангасан тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэлд 6.2-д заасан хувийг харгалзан нэмэгдүүлж болно;
- 6.4. “ЭТТ” ХК-тай нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулсан “Худалдан авагч” тал нь Цагаанхадны НАБТ-н үлдэгдэл, борлуулалтын гэрээнээс хамаарч тухайн улиралд өөрийн нүүрсийг тээвэрлэх ААН-тэй “Нүүрс тээвэрлэх гэрээ”-г байгуулж улс хооронд байнгын ачаа тээвэрлэх “С” зөвшөөрлийн хүсэлтийг баталгаажуулах саналыг ЭТТ ХК-д уламжилж зөвшөөрөл авсан тохиолдолд Нүүрс тээвэр гүйцэтгэх гэрээнээс өөр гэрээний ачилт хийсэн тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийг дараа улирлын улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх “С” зөвшөөрөл олгох хүсэлтийг баталгаажуулахаас татгалзана;
- 6.5. “ЭТТ” ХК нь Тээвэрлэгчийн улс хоорондын ачаа тээвэрлэлтийн хүсэлтийг сонгон баталгаажуулж “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т хүргүүлнэ;

## ДОЛОО. БУСАД

- 7.1. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарагдсан өдрөөс энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно;
- 7.2. Гэрээг адил хүчинтэй 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг авна;
- 7.3. Тээвэрлэгч нь гэрээний үүргээ зөрчсөн гэж “ЭТТ” ХК-иас үзвэл хэдийд ч энэхүү гэрээг цуцалж болно;
- 7.4. Тээвэрлэгч энэхүү гэрээтэй холбоотой маргаантай асуудлыг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ;
- 7.5. Тээвэрлэгчийн гэрээнд бичигдсэн хаягийг албан ёсны хаяг гэж үзэх ба өөрчлөлт орсон тохиолдолд 7 хоногийн дотор бичгээр болон цахим хуудсаар (и-мэйл, факс, шуудан) заавал “ЭТТ” ХК-д мэдэгдэнэ. Аливаа албан баримтыг албан ёсны хаягаар илгээх ба мэдэгдээгүйн улмаас үүдэн гарах үр дагаврыг тухайн тал өөрөө хариуцна;

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“ЭТТ” ХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ТЭЭВЭР ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

ТЭЭВЭРЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
“.....” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ЭЛДЭВ-ОЧИР

.....

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Жигжиджавын гудамж 8, Финанс төв.  
Утас: 70118585

Хаяг: .....  
Утас: .....

#  
#  
#  
#  
#  
#

ТЭЭВЭРЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

А. Тээвэрлэгч компанийн бүрдүүлэх баримт бичиг		Бүрэн эсэх
1.	Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ байгуулах хүсэлт бүхий албан бичигт дараах мэдээллийг тусгана. Үүнд: 1. Албан хүсэлт 2. Компанийн товч танилцуулга, удирдлагын нэр, утас, цахим шуудан 3. Тээврийн хэрэгслийн тоо, жолоочийн тоог дурдах;	
2.	Улсын бүртгэлийн гэрчилгээ болон компанийн дүрмийн нотариатоор баталгаажуулсан хуулбар; /Үйл ажиллагааны чиглэл ачаа тээвэрлэх гэсэн байх/	
3.	Инженер техникийн ажилтан, тээвэр зохицуулагч, ХАБ-ын ажилтан тус бүрийн хөдөлмөрийн гэрээ, мэргэшсэн үнэмлэх эсхүл дипломны нотариатаар баталгаажуулсан хуулбар; /жолооч нартай байгуулсан хөдөлмөрийн гэрээг сканердаж хавсаргах/	
4.	Улс хоорондын байнгын ачаа тээвэр гүйцэтгэхэд тавигдах шаардлага хангаж буй авто тээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх;	
5.	“ЭТТ” ХК-ийн цахим тээврийн GPS-ийн программтай холбогдсон байх; /GPS-ийн гэрээний хуулбар/	
6.	Өөрийн эзэмшлийн эсвэл түрээсээр ашиглах барилга байгууламжийн /жолооч нарын амрах хооллох байр, тээврийн хэрэгслийн засвар, оношилгоо-үйлчилгээ болон тээврийн хэрэгслийг хадгалах дулаан байр, зогсоол, талбай бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ, тээврийн удирдлагын барилга байгууламж байгууламж/ фото зураг, улсын бүртгэлийн болоод газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар болон түрээсийн гэрээний хуулбарыг нотариатаар баталгаажуулах;	
7.	Нийгмийн даатгалын тайлангийн сүүлийн 1-3 сарын тайлан баталгаажуулсан байх;	
8.	Тээврийн хэрэгслийн жагсаалт, жолооч нарын жагсаалт үнэмлэхийн хамт;	
9.	Тээврийн хэрэгслийн гэрчилгээ; /Техникийн хяналтын үзлэг, тооллогод хамрагдаж замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрөл, гэрчилгээ авсан эсэх/	
10.	Даатгалын гэрээний хуулбар; /Жолоочийн хариуцлагын даатгал/	
11.	Хучилтын гэрээний төлбөр тооцоогүй байх;	
12.	Зам ашиглах гэрээ байгуулсан байх, төлбөрийн үлдэгдэлгүй байх;	

#